



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/314

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтан төлийн эзэн, Улсын аварга малчдад олгосон бэлэг дурсгалын зардалд 1 519 500 төгрөг, Баруун бүсийн тэргүүний сумын шагнал захиалан хийлгэхэд 453 000 төгрөг, Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн хэлэлцүүлгийн зардалд 115 000 төгрөг, Төрийн тахилгат Алтан хөхий уулын хөрс шорооны дээжийг музейд хүргэх арга хэмжээний зардалд 205 000 төгрөг, аймгийн Засаг дарга, орлогч дарга нар сумдад ажилласан гарын бэлэгний зардалд 824 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 116 500 төгрөг /Гурван сая нэг зуун арван зургаан мянга таван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/314 Ch

02 01379